

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АТГ	Авлигатай тэмцэх газар
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ХШУДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Нингэнтэй дүүрэг
Бага тогтруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 2-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

2019.03.25 № 01/590
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Санал дүгнэлт өгөхөөс татгалзах

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн санал дүгнэлт өгөхөөс татгалзаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус санд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


- ЖДҮХС-гийн 2012 оноос хойш олгосон ЖДҮ-ийг дэмжих зорилгоор олгосон зээлийн сонгон шалгаруулалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой баримт, материалуудыг АТГ болон Эрүүгийн цагдаагийн газар шалгаж байгаагаас тус сангийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар дүгнэлт гаргахад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц аудитын хангалттай ба зохистой нотлох зүйл байхгүй,
- Тус сангийн 2018 онд ЖДҮ-ийг дэмжих зорилгоор олгосон зээлийг зохих ёсоор тусгаж, үнэн шудрага илэрхийлсэн эсэхийг тодорхойлох боломжгүйгээс санхүүгийн тайлан бүхэлдээ буруу илэрхийлэгдсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал", "Хэмжилт", "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Сангийн удирдага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сангийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Засгийн газрын тусгай сан нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 3 дугаар сарын 05-наас 2019 оны 3 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын Ахлах аудитор Р.Цолмон хариуцаж хэрэгжүүлэв.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 28-ний өдрийн 01/180 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эрхэм зорилго нь Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгож, тэднийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулж урт хугацааны, хөнгөлөлттэй зээл олгох;
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн туршлагыг харилцан солилцуулах.

Төрөөс дэмжлэг авч үйл ажиллагаагаа өргөжүүлсэн, ажлын байр бий болгосон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, үзэсгэлэн худалдаанд хамруулах.

Үйл ажиллагааны чиглэл:

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулиар Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж болон жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

- Жижиг, дунд үйлдвэрийн салбарт улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг нэгдсэн удирдлага, бодлогоор хангах;
- Жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбар, чиглэлийн талаар санал боловсруулж, Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх;
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид үзүүлэх төрийн үйлчилгээг нээлттэй, шуурхай хүргэх, шат дамжлагыг багасгах, хяналт шалгалт, бүртгэл, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ авах санал боловсруулж зохих байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх;
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зориулсан үндэсний болон олон улсын хэмжээний үзэсгэлэн, худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах;
- Жижиг, дунд үйлдвэрийн талаар шаардлагатай судалгааг тогтмол явуулж, үр дүнг нийтэд мэдээлэх гэх мэт.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн удирдлага Засгийн газрын тусгай сангийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь ХХААХҮС-ын 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг баримтлан ажиллаж байгаа боловч тус сангийн санхүүгийн үйл ажиллагааны тусгайлсан бодлого, үндсэн болон зээлийн хүүг хэрхэн тусгах талаар тусгаагүй байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн

технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлаггүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” програм хангамж ашигладаг байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөгүй” гэж үзлээ.

ХХААХҮЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас АТГ-ын 2018 оны 06/4562 дугаар албан бичиг болон ХХААХҮЯ-ны ТНБД-ын удирдамжийн дагуу тус сангийн 2018 оны зээл, төслийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд хэсэгчилэн хяналт хийж, үнэлэлт, дүгнэлт өгсөн байна.

ХШҮДАГ-аас нийт 58.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах акт тогтоож, хэрэгжилтийг ханган ажиллуулах 7 зөвлөмж өгсөн байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1.0 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар материаллаг байдлын суурийг сонгосон нь тоон болон шинж чанарын хувьд материаллаг гэж үзэн нийт зардалд ЖДҮ-ийн зээлийн зарцуулалт хамаарагдаж байгаагаас гадна эрсдэл их гэж үзэн сонгон авав.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2018 оны нийт зардал 2,019.6 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 20.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь материаллаг буруу илэрхийллийн эрсдэл өндөр гэж үзэж байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй

асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөг)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	864.6	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.0	
3	Албан шаардлага өгсөн	1	2,908.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.0	
	Дүн	3	3,772.6	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1.Аудитын явцад хийсэн залруулга

- Санхүүгийн тооцоолох групп ХХК-нд олгосон зээлийн програмын урьдчилгаа 21.2 сая төгрөгийг урьдчилж гарсан зардал дансанд,
- СЯ-тай зээлийн тооцоо нийлсэн актаар баталгаажсан 383.9 сая төгрөгийн алдангийг өглөг дансанд тусгасан,
- Өсөх их ирээдүй ХХК-нд олгосон 5.4 сая төгрөгийг тооцоо нийлж, баталгаажуулсан тул зардал дандсан бүртгэсэн,
- Эзэн холбогдогч нь тодорхойгүй 28.1 сая төгрөгийн зээлийн төлөлтийг урьдчилж орсон орлого дансанд бүртгэж аудитын явцад тус тус залруулав.

2. Албан шаардлага

ЖДҮХС-гийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор 2009 оноос хойш олгосон Арилжааны банкнаас авах зээлийн авлага, Ахуй үйлчилгээний төв болон бөөний худалдааны зээл, Оёдлын үйлдвэрүүдийн нэгдсэн холбоо, Сүү төслийн болон Түүхий эдийн төв байгуулах, Хөдөлмөрийн сайд /хуучнаар/, Хүнс, хөдөө аж ахуйн сайд /хуучнаар/-уудын тушаалуудаар олгосон зээл зэрэг нийт 291,428.5 сая төгрөгийн авлага тусгагдсаны 1.0 хувь буюу 2,908.0 сая төгрөгийн авлага болон зээлийн хүүгийн үлдэгдэлд тооцоо нийлээгүй байна.

Энэ нь Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж, аудитын “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй тул зээлийн хүүгийн авлага, бусад тооцооны авлагыг баталгаажуулах талаар албан шаардлага өгөв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2018 оны санхүүгийн тайланд ЖДҮ-ийг хөгжүүлэх зорилгоор олгосон зээлийн авлага 291,428.5 сая төгрөг буюу 99.9 хувийг эзэлж байна.

Тус сангийн 2012 оноос хойш олгосон ЖДҮ-ийг дэмжих зорилгоор олгосон зээлийн сонгон шалгаруулалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой баримт, материалуудыг АТГ болон Эрүүгийн цагдаагийн газар шалгаж байгаагаас тус сангийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар санал дүгнэлт гаргахад аудитын хангалттай ба зохистой нотолгоог олж авах боломжгүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын тусгай сан нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 6 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 99,188.8 сая төгрөгийн төсөв

батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 97,144.8 сая төгрөг буюу 97.9 хувь, зардлын нийт гүйцэтгэл 97,145.2 сая төгрөг буюу 97.9 хувьтай байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоонд хангах хүрээнд тус сан өөрийн цахим хуудсаар <http://mofa.gov.mn> байршуулсан байна.

Тус сангийн Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу албан тушаалтан хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа эсэхийг аудитаар анхаарч үзлээ. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн шилэн дансны сайтад бүрэн хамрагдсан бөгөөд шилэн дансны цахим хуудсанд 2018 онд орлогын 125,129.8 сая төгрөгийн 814 мэдээлэл, зарлагын 129,320.1 сая төгрөгийн 248 мэдээлэл байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 65.6 хувь, албан шаардлагын хэрэгжилт 63.2 хувь байна.

ЖДҮХС-гийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 15,789.0 сая төгрөгийн 11 зөвлөмж өгсөнөөс 4 зөвлөмж бүрэн биелэгдэж, 6 зөвлөмж хэрэгжих шатандаа, 1 зөвлөмж хэрэгжээгүй байна. Тухайлбал:

Хэрэгжих шатандаа байгаа зөвлөмжүүд:

- "Эн ви си" ХХК-ны 601.0 сая төгрөгийн хөрөнгийг тус сангийн эргэлтийн хөрөнгөд бүртгэх талаар ХХААХҮС-ын 2019 оны А/69 дүгээр тушаал гарсан боловч 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хөрөнгөөр бүртгээгүй,
- 2018 оны эхний санхүүгийн тайланд 2,908.0 сая төгрөгийн зээлийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй,
- Анхан шатны баримтын бүрдэлгүй, юуны авлага болох нь тодорхойгүй нийт 118.1 сая төгрөгийн авлагаас 76.7 сая төгрөгийн авлагын эзэн холбогдогчийг тогтоон авлагыг барагдуулсан,
- ЖДҮХС-гийн 2017 оны санхүүгийн тайланд тусгасан нийт 667.6 сая төгрөгийн зээлийн авлагын хүүг зээл олгох гэрээ байгуулсан өдрөөс эхлэн зээл төлөгдөх нийт хугацаагаар буюу 5 жилийн хүүгийн авлагыг тооцож бүртгэсэнээс 130.6 сая төгрөгөөр хорогдуулан тооцсон,
- "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-тай зээлийн тооцоолол, санхүү бүртгэлийн програм хангамж нийлүүлэлтийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Хэрэгжүүлээгүй завлөмж:

- Хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулах эрх зүйн актыг баримтлан ажиллах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.

ЖДҮХС-гийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,973.7 сая төгрөгийн 3 албан шаардлага өгсөнөөс 2 албан шаардлага бүрэн биелэгдэж, 1 албан шаардлага хэрэгжих шатандаа байна. Тухайлбал:

Хэрэгжих шатандаа байгаа албан шаардлага:

- 2013 оноос хойш олгосон 330 зээлдэгчийн гэрээнд тусгасан зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу 2017 онд төлөх 54 зээлдэгчийн 928.6 сая төгрөгийн үндсэн зээл, 135 зээлдэгчийн 165.3 сая төгрөгийн хүүгийн төлбөр тус тус төлөгдөөгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлага

3.1.1 Илрүүлэлт:

Тус сан тайлант оны санхүүгийн тайланд 35 зээлдэгчийн 855.4 сая төгрөгийн зээлийн хүүгийн алданги болон нэмэгдүүлсэн хүүг тооцож, барагдуулах арга хэмжээг аваагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т заасан “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, аудитын “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Шийдвэрлэсэн нь:

НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-г баримтлан ажиллаж дээрх зээлийн хүүгийн алданги болон нэмэгдүүлсэн хүүг тооцож барагдуулах талаар зөвлөмж өгөх.

3.1.3 Эрсдэл

Үнэн зөв байдал-Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

Эрх ба үүрэг-Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, төлөх үүрэгтэй байх.

3.1.4 Төсвийн захирагчийн хариу:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.2 Авлага

3.2.1 Илрүүлэлт:

ЖДҮХС 2017 онд албан хаагчдын амралт болон өдөрлөг зохион байгуулахаар “Төв түшээ” ХХК-д 9.2 сая төгрөгийг шилжүүлсэн боловч уг үйл ажиллагааг зохион байгуулаагүй атал зардлын дансанд хааж бичсэн байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх гэснийг зөрчсөн байна.

3.2.2 Шийдвэрлэсэн нь:

“Төв түшээ” ХХК-д олгосон 9.2 сая төгрөгийг авлага дансанд бүртгэж, авлагыг барагдуулах арга хэмжээ авах талаар зөвлөмж өгөх.

3.2.3 Эрсдэл

Үнэн зөв байдал-Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

Эрх ба үүрэг-Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, төлөх үүрэгтэй байх.

3.2.4 Төсвийн захирагчийн хариу:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/6/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан				Сая төгрөг

№	Аудитын зорилт, чиглэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	3	4	5	9	10
1	Авлага	ЖДҮХС-гийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор 2009 оноос хойш олгосон Арилжааны банкнаас авах зээлийн авлага, Ахуй үйлчилгээний төв болон бөөний худалдааны зээл, Оёдлын үйлдвэрүүдийн нэгдсэн холбоо, Сүү төслийн болон Түүхий эдийн төв байгуулах, Хөдөлмөрийн сайд /хуучнаар/, Хүнс, хөдөө аж ахуйн сайд /хуучнаар/-уудын тушаалуудаар олгосон зээл зэрэг нийт 291,428.5 сая төгрөгийн авлага тусгагдсаны 1.0 хувь буюу 2,908.0 сая төгрөгийн авлага болон зээлийн хүүгийн үлдэгдэлд тооцоо нийлээгүй байна.	2,908.0	Албан шаардлага өгсөн.	1.ЖДҮХС-гийн захирал /асан/ 2.Санхүү, хөрөнгийн хэлтсийн дарга 3.Ерөнхий нягтлан бодогч	1.С.Төгсбилэг 2.Р.Гантөмөр 3.А.Цагаанцэцэг
2	Авлага	Тус сан тайлант оны санхүүгийн тайланд 35 зээлдэгчийн 855.4 сая төгрөгийн зээлийн хүүгийн алданги болон нэмэгдүүлсэн хүүг тооцож, барагдуулах арга хэмжээг аваагүй байна.	855.4	Зөвлөмж өгсөн.	1.ЖДҮХС-гийн захирал /асан/ 2.Санхүү, хөрөнгийн хэлтсийн дарга 3.Ерөнхий нягтлан бодогч	1.С.Төгсбилэг 2.Р.Гантөмөр 3.А.Цагаанцэцэг

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	Авлага	ЖДҮХС 2017 онд албан хаагчдын амралт болон өдөрлөг зохион байгуулахаар “Төв түшээ” ХХК-д 9.2 сая төгрөгийг шилжүүлсэн боловч уг үйл ажиллагааг зохион байгуулаагүй атал зардлын дансанд хааж бичсэн байна.	9.2	Зөвлөмж өгсөн.	1.ЖДҮХС-гийн захирал /асан/ 2.Санхүү, хөрөнгийн хэлтсийн дарга 3.Ерөнхий нягтлан бодогч	1.С.Төгсбилэг 2.Р.Гантөмөр 3.М.Энхзаяа
Нийт дүн			3,772.6			